

ПИРОТЕХНИКИЙН ХЭРЭГСЛИЙГ ҮЙЛДВЭРЛЭХ, ИМПОРТЛОХ, АШИГЛАХ ДҮРЭМ

Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийг Зөвшөөрлийн тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасны дагуу пиротехникийн хэрэгсэлтэй холбогдох тусгай зөвшөөрлийг авсан аж ахуйн нэгж байгууллага, үзвэрийн зориулалттай пиротехникийн хэрэгсэл ашиглахаар мэргэжлийн туслалцаа авч байгаа захиалагч болон хэрэглэж буй байгууллага, хэрэглээний зориулалттай пиротехникийн бүтээгдэхүүн хэрэглэж байгаа хувь хүмүүс дагаж мөрдөнө.

1.2. Энэхүү дүрэм нь пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, бүртгэх, тохирол, үл тохирлыг тогтоох үйл ажиллагааны харилцаа, тэдгээртэй холбоотой аюулгүй ажиллагааны горим, хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийг хамгаалахад мөрдөх шаардлагуудыг тогтооно.

Түүнчлэн энэхүү дүрэм нь хэрэглэгчдийг пиротехникийн хэрэгслийн зориулалт, аюулгүй байдлын талаарх буруу ойлголт, үйлдлээс урьдчилан сэргийлнэ.

1.3. Пиротехникийн хэрэгслийг аюулын зэргийн түвшингээр А, В, С, D гэж ангилах ба А, В үзвэрийн зориулалттай, С, D хэрэглээний зориулалттай гэнэ.

1.3.1. А ангиллын пиротехникийн хэрэгсэл нь цохилтын долгионгүй, бусад хүчин зүйлийн аль нэг хүчин зүйлийн үүсгэх аюултай бүсийн радиус нь 30 м-ээс их байх бөгөөд пиротехникийн хэрэгслийн мэргэжилтэн холбож, тусгаарласан нөхцөлд бууддаг бүтээгдэхүүн,

1.3.2. В ангиллын пиротехникийн хэрэгслийн хөдөлгөөний кинетик энерги нь тухайн бүтээгдэхүүн чиглэсэн хөдөлгөөнтэй бол 5 Ж-оос ихгүй, чиглэсэн хөдөлгөөнгүй бол 20 Ж-оос ихгүй байх, цохилтын долгионгүй, аюултай бүсийн хязгаараас давсан бутармаг, хэлтэрхийн цацалтгүй, пиротехникийн бүтээгдэхүүнээс 5 м зай дахь шуугианы цацралт 140 дБ-ээс хэтрэхгүй, бусад хүчин зүйлээс үүсэх аюултай бүсийн радиус 30 м-ээс ихгүй байна. Задгай, том талбайд буудах зориулалттай бүтээгдэхүүн,

1.3.3. С ангиллын пиротехникийн хэрэгслийн хөдөлгөөний кинетик энерги нь 5 Ж-оос ихгүй, цохилтын долгионгүй, аюултай бүсийн хязгаараас давсан бутармаг, хэлтэрхийн цацалтгүй, пиротехникийн бүтээгдэхүүнээс 2.5 м зай дахь шуугианы цацралт 140 дБ-ээс хэтрэдэггүй, бусад хүчин зүйлээс үүсэх аюултай бүсийн радиус 5 м-ээс илүүгүй байх, гадаа задгай талбайд хэрэглэх бүтээгдэхүүн,

1.3.4. D ангиллын пиротехникийн хэрэгслийн хөдөлгөөний кинетик энерги нь 0.5 Ж-оос ихгүй, цохилтын долгионгүй, аюултай бүсийн хязгаараас давсан бутармаг, хэлтэрхийн цацалтгүй, пиротехникийн бүтээгдэхүүнээс 0.25 м зай дахь шуугианы цацралт 125 дБ-ээс хэтрэхгүй, бусад хүчин зүйлээс үүсэх аюултай бүсийн радиус нь 0.5 м-ээс илүүгүй байна. Бүтээгдэхүүний ашиглах зааврын дагуу хүний гар дээрээс буудуулахад аюулгүй бүтээгдэхүүн,

1.3.5. Бусад улсын пиротехникийн хэрэгслийн ангилал зөрүүтэй байвал импортолсон бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө үндсэн үзүүлэлтээр нь Монгол улсын ангилалд нийцүүлнэ.

1.4. Монгол Улсад үйлдвэрлэх, импортлох, ашиглах пиротехникийн хэрэгсэл, пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэхэд хэрэглэгдэх түүхий эд нь үндэсний болон олон улсын стандартын шаардлагыг хангасан байна.

1.5. Монгол улсад стандартаар тогтоосон хязгаартай түүхий эдийг хязгаарын хэмжээнээс хэтрүүлж ашиглах, ашиглахыг зөвшөөрөөгүй түүхий эд хэрэглэхийг хориглоно.

1.6. Үзвэрийн зориулалттай пиротехникийн хэрэгслийг ашиглах хуулийн этгээд пиротехникийн хэрэгслийн мэргэжилтэнтэй байна.

1.7. Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэгчийн тогтоосон аюултай байдлын зэрэглэлийн анги, хэрэглэх зааврын дагуу ашиглана.

Хоёрдугаар зүйл. Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх

2.1. Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх үйлдвэр батлагдсан технологийн болон барилгын зураг төсөлтэй байна.

2.2. Технологийн зураг төсөл нь “Тэсрэх бодисын үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлага ба хүлээн авах заавар”-т заасан шаардлагыг хангасан байна.

2.3. Пиротехникийн хэрэгслийн үйлдвэр “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийн шаардлагыг хангасан байна.

2.4. Пиротехникийн хэрэгслийн үйлдвэрийн тоног төхөөрөмж нь үндэсний болон олон улсын холбогдох стандарт, дүрмийн шаардлагыг хангасан гарал үүсэлтэй байна.

2.5. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь “Монгол Улсад ашиглах үзвэрийн болон хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийн жагсаалт”-д заасан, тухайн төрлийн бүтээгдэхүүний стандартад тохирсон байна.

2.6. Пиротехникийн хэрэгслийн үйлдвэр, агуулахын барилга байгууламж нь пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх зориулалтаар ашиглахыг зөвшөөрсөн улсын комиссын шийдвэртэй байна.

2.7. Үйлдвэрийн технологийн зураг төслийг үндэслэн боловсруулсан үйлдвэрийн үйл ажиллагааны технологийн горимыг байгууллагын техникийн удирдагч батална. Батлагдсан үйлдвэрийн үйл ажиллагааны технологийн горим нь байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх баримт бичиг болно.

2.8. Пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэхэд технологийн горим болон аюулгүй ажиллагааны зааврын дагуу, технологийн процессыг аюулгүй явуулах шаардлага хангасан хэмжих, шалгах багаж, тоног төхөөрөмж ашиглана.

2.9. Пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэгч үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, технологид өөрчлөлт хийх тохиолдолд “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон “Тэсрэх бодисын үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлага ба хүлээн авах заавар”-ын дагуу зураг төсөлдөө өөрчлөлт оруулсан байна.

2.10. Пиротехникийн хэрэгсэл нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- а) А-D ангиллын пиротехникийн хэрэгсэл нь түүнд угсарсан асаах төхөөрөмж болон гаднын №8 стандартын цахилгаан тэслүүрийн үйлчлэлээс тэсрэлт авахааргүй байна. Бүтээгдэхүүн тохиолдлоор ажиллахад зэргэлдээ байгаа (савлагаатай) ижил бүтээгдэхүүнийг өдөөж ажиллуулахааргүй байна.
- б) Өндөрт эффект үүсгэх ахуйн хэрэглээний зориулалттай пиротехникийн бүтээгдэхүүний ажиллаж эхлэх хүртэлх удаашруулах хугацаа нь хэрэглэгчийг аюулгүй зайд холдоход хангалттай хүрэлцэхүйц байх бөгөөд, түүнийг ашиглалтын зааварт заасан байна.
- в) Буудлагын пиротехникийн хэрэгслийг ашиглалтын баримт бичигт дараах нэмэлт мэдээллийг тусгана. Үүнд:
 - Мортирт үүсэх даралтын дээд хэмжээ (буудлагын төхөөрөмжид үзүүлэх бусад хүчний үйлчлэл);
 - Үзүүлэх эффектийн тайлбар;

- Задралын өндрийг заасан байх (хөөрөлт);
 - Пиротехникийн элементийн шатаж дуусах боломжит өндрийг заасан байх;
 - Салхины хурдыг тооцсон аюултай бүсийн радиус;
 - Гал дамжуулах шижмээр тоноглогдсон бүтээгдэхүүний удаашруулалтын хугацаа;
 - Тохирох мортирын хэмжээсүүд (диаметр, яндангийн ажлын хэсгийн урт).
- г) Энэхүү дүрмийн шаардлагыг ханган зохион бүтээсэн пиротехникийн хэрэгсэл нь түүнтэй харьцах бүх шатанд зориулсан хийц бүтцийн болон технологийн баримт бичигтэй байна.
- д) Пиротехникийн хэрэгсэлд түүнтэй харьцах бүх шатны аюултай хүчин зүйлийг тодорхойлсон байна. Үүнд:
- Хэрэглэсэн пиротехникийн бодисын шинж чанар;
 - Пиротехникийн хэрэгслийн гаднын хүчин зүйлийн үйлчлэлд мэдрэмтгий чанар;
 - Пиротехникийн хэрэгслийн болон түүний савлагаа, боодлын бүтцийн онцлог;
 - Пиротехникийн хэрэгслийг ашиглах нөхцөл, ашиглах арга;
 - Пиротехникийн хэрэгслийг устгах, дахин боловсруулах арга.
- е) Хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийг дөл дарах хэрэгсэл агуулсан болон галаас хамгаалах боловсруулалт хийгдсэн үйлдвэрийн сав, баглаатай тээвэрлэнэ.

2.11. Пиротехникийн хэрэгслийн сав, баглаа боодлын гадна талд бүтээгдэхүүний нэр, үйлдвэрийн нэр, хаяг, үйлдвэрлэсэн болон хадгалах баталгаат хугацаа, тэсэрч дэлбэрэх аюултайг анхааруулсан таних тэмдэг, аюулгүй байдлын санамжийг тусгасан байна.

2.12. Пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэхэд энэхүү дүрмийн 20-р заалтад заасны дагуу туршилт хийлгэн, шинжээчийн дүгнэлт гаргуулж, стандарт батлуулсан байна.

2.13. Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх үйлдвэрийн хог хаягдлыг “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон аюултай хог хаягдлын тухай холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд дахин боловсруулах буюу устгана.

Гуравдугаар зүйл. Пиротехникийн хэрэгслийг импортлох

3.1. Импортоор оруулж ирсэн пиротехникийн хэрэгслийн хэсэг бүрийг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага нь аюулгүй ажиллагааны шаардлага хангасан зориулалтын туршилтын талбайд түүнийг хэмжих тусгай зориулалтын багаж, төхөөрөмжөөр туршин шалгаж, ашиглаж болох талаар акт гаргаж 3 хувь үйлдэн, нотлох баримтын хамт хувь тус бүрийг гаалийн болон хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад, үлдэх хувийг эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага хадгална.

3.2. Пиротехникийн хэрэгсэл импортлогч байгууллага уг бүтээгдэхүүнийг Монгол улсын нутаг дэвсгэрт энэхүү дүрмийн дагуу хэрэглэхэд тохирсон эсэхийг нотлохын зэрэгцээ, үйлдвэрлэгчийн нэрийн өмнөөс пиротехникийн бүтээгдэхүүний үл тохирлын хариуцлагыг хүлээхээр үйлдвэрлэгчтэй гэрээний үндсэн дээр тохиролцсон байна.

3.3. Геологи, уул уурхайн Салбарын хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага холбогдох хуулийн шаардлага хангасан шинжээчээр дүгнэлт гаргуулж болно.

3.4. Импортлох пиротехникийн хэрэгслийн сав, баглаа боодлын гадна талд бүтээгдэхүүний нэр, үйлдвэрийн нэр, хаяг, үйлдвэрлэсэн болон хадгалах баталгаат

хугацаа, тэсэрч дэлбэрэх аюултайг анхааруулсан таних тэмдэг, аюулгүй байдлын санамж, хэрэгжилтийн стандарт кодтой байна.

3.5. Монгол Улсад импортлох, ашиглах пиротехникийн хэрэгсэл нь олон улсын стандартын шаардлагыг хангасан байна.

Дөрөвдүгээр зүйл. Пиротехникийн хэрэгслийг хадгалах

4.1. Пиротехникийн хэрэгслийг тухайн бүтээгдэхүүний аюултай байдлын зэргийн ангилал, ашиглалтын зааврын дагуу галын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан агуулахад хадгална.

4.1.1. Үзвэрийн зориулалттай пиротехникийн хэрэгслийг зориулалтын агуулахад Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасан нөхцөлийн дагуу хадгална.

4.1.2. Хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийг галын аюултай материал, хэрэгсэл хадгалах шаардлага хангасан агуулахад хадгална.

4.1.3. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон (акталсан) пиротехникийн хэрэгслийг зөвхөн агуулахад тусгайлан гаргаж, тэмдэгжүүлсэн байранд түр хадгална. Сав баглаа гэмтэж битүүмжлэл алдагдан, харьцахад аюул учруулах эрсдэлтэй пиротехникийн хэрэгслийг битүүмжлэн тусгай байранд, эсвэл тусгай савлагаатай хадгална.

4.1.4. Пиротехникийн хэрэгслийг зориулалтын агуулах болон жижиглэн худалдааны агуулах, танхимд тавиур, тавцан дээр хурааж хадгална.

4.1.5. Иргэн хувийн хэрэгцээндээ авсан хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийг, тухайн бүтээгдэхүүнийг хэрэглэх зааврын дагуу хадгалах үүрэгтэй.

4.2. Пиротехникийн хэрэгслийн хадгалалтын нөхцөл байдалд тухайн нутаг дэвсгэрийн онцгой байдал, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт тавина.

Тавдугаар зүйл. Пиротехникийн хэрэгслийг худалдах

5.1. Пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох эрх бүхий байгууллага үзвэрийн зориулалттай пиротехникийн хэрэгслийг энэхүү дүрмийн 5-д заасан байгууллагад ашиглах заавар, аюулгүй ажиллагааны заавар, хог хаягдлыг аюулгүй болгох зааврын хамт худалдана.

5.2. Пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох эрх бүхий байгууллага хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийг хувь хүн болон бусад аж ахуйн нэгж байгууллагад ашиглах заавар, аюулгүй ажиллагааны заавар, хог хаягдлыг аюулгүй болгох зааврын хамт худалдана.

5.3. Пиротехникийн хэрэгслийг эрх бүхий байгууллагаас худалдан авсан байгууллага, хувь хүн хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийг жижиглэнгээр худалдан борлуулахдаа бүтээгдэхүүний шинж чанар алдагдахгүй байх нөхцөл хангасан орчинд, нарны гэрлийн шууд тусгал, борооны ус, дусаалын нөлөөгүй байранд байрлуулна.

Худалдааны байрны талбайн даацыг 25 кв.м талбайд бохир жингээрээ 1200 кг-аас илүүгүй жинтэй пиротехникийн хэрэгсэл байхаар тооцно. 25 кв.м-аас бага талбайтай худалдааны байранд нэг дор байх пиротехникийн хэрэгслийн жин 333 кг-аас хэтрэхгүй.

5.4. Хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгсэл борлуулах дэлгүүр онцгой тохиолдолд хүн саадгүй гарах нөхцөл бүрдүүлсэн, гал унтраах болон галын дохиоллын хэрэгслээр хангагдсан байна.

5.5. Хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийг дулааны эх үүсвэрээс хол байрлуулна. Пиротехникийн хэрэгсэл агуулсан байранд тэдгээрт механик болон дулааны үйлчлэл үзүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

5.6. Хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийг жижиглэнгээр борлуулах худалдагч худалдан авагчид бүтээгдэхүүний ашиглалтын заавар зөвлөгөө өгөх мэдлэгтэй байна. Худалдан авагчийг дэлгүүрт пиротехникийн хэрэгсэлтэй шууд харьцахыг хориглоно.

Зургаадугаар зүйл. Пиротехникийн хэрэгслийг тээвэрлэх

6.1. Пиротехникийн хэрэгслийг тээвэрлэх, ачих, буулгахад үйлдвэрлэгчээс тодорхойлсон аюултай ачааны ангиллын зэргийг баримтална.

6.2. Үзвэрийн зориулалттай пиротехникийн хэрэгслийг тээвэрлэхэд “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”-ыг баримтална.

6.3. Хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийг галын аюулгүй байдлыг хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

Долоодугаар зүйл. Пиротехникийн хэрэгслийг ашиглах

7.1. Пиротехникийн хэрэгслийг ашиглахад үйлдвэрлэгчийн тогтоосон аюултай байдлын зэрэглэлийн ангилал болон үйлдвэрлэгч, худалдагч этгээдээс дагалдаж өгсөн зааврыг баримтална.

7.2. Үзвэрийн зориулалтаар пиротехникийн хэрэгслийг ашиглахад тухайн нутаг дэвсгэрийн цагдаа, онцгой байдлын байгууллага хяналт тавина. Кино зураг авалтын үед пиротехникийн хэрэгслийг ашиглах үйлд ажиллагаанд кино зургийн дарга болон продюссер хяналт тавина.

7.3. Үзвэр зохион байгуулагч, ашиглагч байгууллага, кино үйдвэрлэлийн байгууллага үзвэрийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны зааварчилгааг энэхүү дүрэмд нийцүүлэн хамтран боловсруулж, мөрдөнө.

7.4. Үзвэрийн зориулалттай пиротехникийн хэрэгсэл буудуулах ажлыг пиротехникийн хэрэгслийн мэргэжилтэн гүйцэтгэнэ.

7.5. Пиротехникийн хэрэгсэл ашиглагч байгууллага олон нийтийг хамарсан арга хэмжээнд буудлагын хариуцлагатай удирдагч томилсон байна. Пиротехникийн хэрэгслийг ашиглагч кино үйлдвэрлэлийн байгууллага нь тусгай эффе́кттэй кино зураг авалтын нийт оролцогчдод мэргэжилтнээр анхааруулга, зааварчилгаа өгүүлж, урьдчилан төлөвлөж сургуулилт гүйцэтгэнэ.

7.6. Үзвэрийн зориулалттай пиротехникийн хэрэгслийг тухайн хэрэгслийн ашиглалтын зааварт заасан барилга байгууламжийн аюултай бүсийн зайнаас гаргаж ашиглана.

7.7. Пиротехникийн хэрэгслийг ашиглах мэргэжилтэн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангасан хувцас, хэрэгсэл хэрэглэнэ.

7.8. Хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийг хадгалах, ашиглах үед бүтээгдэхүүний болон цахилгаан асаагуур төхөөрөмжийг шалгахыг хориглоно.

7.9. D ангиллын бүтээгдэхүүнд өдөөлтийн цахилгаан хэлхээтэй систем хэрэглэхийг хориглоно.

7.9. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн хүн пиротехникийн хэрэгсэл ашиглахыг хориглоно.

7.10. Тухайн хэрэглэгч байгууллагад пиротехникийн бодисын Хор аюулын лавлах материал (ХАЛМ)-ыг Монгол орчуулгын хамт хүргүүлсэн байна.

Наймдугаар зүйл. Пиротехникийн хэрэгслийн мэргэжилтэн

8.1. Пиротехникийн хэрэгслийн мэргэжилтэн нь бүрэн дундаас дээш боловсролтой, 18-с дээш насны Монгол улсын иргэн байна.

8.2. Пиротехникийн хэрэгслийн мэргэжилтэн тусгай эрхийн үнэмлэхтэй байна. Үнэмлэх олгох, сунгах, хүчингүй болгох, бүртгэхэд “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг баримтална.

8.3. Пиротехникийн хэрэгслийн мэргэжилтэн холбогдох дүрэм, журмын дагуу пиротехникийн хэрэгслийг хадгалах, тээвэрлэх, ашиглах үйл ажиллагааг зохион байгуулна.

8.4. Пиротехникийн хэрэгслийн мэргэжилтэн пиротехникийн хэрэгслийг ашиглах дүрэм, үзвэр зохион байгуулагчийн баталсан аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөнө.

8.5. Пиротехникийн хэрэгсэл баарсан, гацсан тохиолдолд пиротехникийн хэрэгслийн мэргэжилтэн аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримтлан аюултай бүсээс гаргах, устгах арга хэмжээ авч, цаг алдалгүй цагдаа, онцгой байдал болон хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

8.9. Үзвэр зохион байгуулах үед пиротехникийн хэрэгслээс шалтгаалсан аюул, осол гарсан тохиолдолд үзвэр зохион байгуулагч аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, иргэн тухайн нутаг дэвсгэрийн цагдаа, онцгой байдлын байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Есдүгээр зүйл. Пиротехникийн хэрэгсэл устгах

9.1. Чанарын шаардлага хангахгүй болсон, ашиглах хугацаа дууссан пиротехникийн хэрэгслийг “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-н дагуу устгах төлөвлөгөө боловсруулж, устгах ба тухайн нутаг дэвсгэрийн цагдаа, онцгой байдлын байгууллага болон хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хяналт тавина.

9.2. Пиротехникийн хэрэгслийг устгасан тухай баримтыг “Мэдээллийн нэгдсэн сан”-д бүртгүүлнэ.

Аравдугаар зүйл. Пиротехникийн хэрэгслийн бүртгэл, тайлан

10.1. Пиротехникийн хэрэгслийг үзвэрийн зориулалтаар ашиглах аж ахуйн нэгж, байгууллага үзвэр зохион байгуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө тухайн нутаг дэвсгэрийн цагдаа, онцгой байдлын байгууллагад бүртгүүлсэн байна.

10.2. Үзвэрийн зориулалттай пиротехникийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах аж ахуйн нэгж, байгууллага геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Уг байгууллага худалдан авсан байгууллага, иргэний бүртгэлийг хөтөлнө.

10.3. Хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгсэл худалдах байгууллага, иргэн нь тухайн нутаг дэвсгэрийн цагдаа, онцгой байдал, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн байна. Уг байгууллага худалдан авсан байгууллага, иргэний бүртгэлийг хөтөлнө.

10.4. Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, үзвэрийн зориулалтаар ашиглах эрх бүхий байгууллага, үйлдвэрлэсэн, импортлосон, хадгалсан, худалдсан, тээвэрлэсэн, ашигласан хэрэгслийн орлого, зарлага, үлдэгдэл, ашиглалтын шаардлага хангахгүй болсон пиротехникийн хэрэгслийн бүртгэл хөтөлж, тайланг Мэдээллийн нэгдсэн сан хөтлөх журмын дагуу геологи, уул

уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил тутам, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад улирал тутам хүргүүлнэ.

10.5. Хэрэглээний зориулалттай пиротехникийн хэрэгслийг худалдаалахаар бүртгүүлсэн байгууллага, иргэн худалдан авсан, ашигласан, шаардлага хангахгүй болсон пиротехникийн хэрэгслийн бүртгэлийн тайланг Мэдээллийн нэгдсэн сан хөтлөх журмын дагуу цагдаа, онцгой байдлын байгууллага болон хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад улирал тутам хүргүүлнэ.

Арваннэгдүгээр зүйл. Хариуцлага

11.1. Энэхүү дүрмийг зөрчсөн, эргэлтийн тайланг худал мэдээлсэн мэдээлэл хариуцагч, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

11.2. Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах талаар иргэд, аж ахуйн нэгжийн гомдол, хүсэлт, мэдээллийг харьяаллын дагуу геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, цагдаа, тагнуул, онцгой байдлын байгууллагууд хүлээн авч шийдвэрлэнэ.

-----oO-----